

## ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 12 дугаар сарын 08

№03

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн (1-203) өрөөнд 14:00 цагаас 76,4 /албан чөлөөтэй гишүүдийг ирцэд тооцов/ хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны Нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа удирдан явуулав.

**Хуралд:** Нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн М.Оюунчимэг, Б.Оюунтунгалаг, Л.Амартүвшин, Г.Өлзийсайхан, Б.Мөнхцэнгэл, Ш.Цоож, Г.Батцэцэг, Д.Ариунболор, Д.Цэрэндолгор, Б.Мөнхцэнгэл, Д.Батдорж, Г.Ариунтөгс нар оролцов.

### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. “071314. Цахилгаан электроник” бакалаврын хөтөлбөр нээх тухай (ЭХС)
  - ЭХС-ийн Цахилгаан техникийн салбарын дэд профессор Б.Нямбаяр
2. “041101. Нягтлан бодох бүртгэл” магистрын сургалт, судалгааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх тухай (ЭЦДС)
  - ЭЦДС-ийн нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн эрхлэгч Л.Баасандорж
3. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрт солонгос хэлний чиглэл нэмэх тухай (ГХС)
  - ГХС-ийн сургалт чанарын албаны дарга А.Болормаа
4. “Харилцааны англи хэл” хичээлийн агуулгыг шинэчлэн, нэрийг өөрчлөх тухай (ГХС)
  - ГХС-ийн сургалт чанарын албаны дарга А.Болормаа

## **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. ЭХС-д шинээр нээх Цахилгаан электроник хөтөлбөрийг ХЕХ хорооны гишүүдийн санал, зөвлөмжийг тусган сайжруулан, БМИҮЗ-д урьдчилсан магдлан итгэмжлэл хийлгэхийг дэмжлээ. Тус хөтөлбөрийн боловсруулалтад санал, зөвлөмж гаргах шинжээчээр ХЕХ-ны гишүүн П.Ууганбаяр, Ш.Цоож нарыг томиллоо
2. ЭЦДС-д Нягтлан бодох бүртгэл магистрын сургалт, судалгааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх тухай асуудлыг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн санал, зөвлөмжийн дагуу БАТС, БуХС-ийн ХДХ-д хэлэлцүүлэн, АТХА хянан баталгаажуулалт хийж, дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
3. ГХС-ийн хариуцан хэрэгжүүлж буй Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт бэлтгэл сургалтын хөтөлбөрт солонгос хэлний чиглэл нэмж, БШУЯ-ны “Бэлтгэл хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө”-г жишиг болгон ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрт тусгасан хичээлийн агуулгатай уялдуулан, сургалтын төлөвлөгөөг баталгаажуулж, хэрэгжүүлэхийг дэмжлээ.
4. “Харилцааны англи хэл” хичээлийн агуулгыг шинэчлэн, нэрийг өөрчлөх тухай (ГХС) асуудалд хөтөлбөрийн ерөнхий хорооны бүх гишүүдийн оролцоог хангах үүднээс цахимаар санал авч шийдвэрлэх.